



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 5 сарын 21 өдөр

Дугаар 1/92

Улаанбаатар хот

### Нийслэлийн ерөнхий боловсролын Боловсрол цогцолбор сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн зөн ОУБ, багш, эмэгтэйчүүдийн зөвлөл, эцэг эхээс хандивласан хавсралтад заасан 6,588,000.0 (зургаан сая таван зуун наян найман мянган) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Боловсрол цогцолбор сургууль (Б.Буянхишиг)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Боловсрол цогцолбор сургууль (Б.Буянхишиг)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В. Оюумаа* В.ОЮУМАА



1150500346

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны  
 ... дугаар сарын ... ны өдрийн дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын Боловсрол цогцолбор сургууль

Д/д	Эд хөрөнгийн нэр	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ /тегрөгөөр/		Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр	Хөрөнгийн эх үүсвэр
							нэгжийн үнэ	нийт дүн		
<b>Тавилга, эд хогшил</b>										
1	Шкаф	ДСП	2024	шинэ	ш	1	450,000	450,000		
2	4хаалгатай цагаан шкаф	ДСП	2024	шинэ	ш	1	790,000	790,000	Багшийн хандив	
3	Бичгийн шүүгээ	Төмөр	2024	шинэ	ш	1	520,000	520,000	Эцэг эхийн хандив	
	Тавилга, эд хогшлын дүн							1,760,000		Хандилагчдын хөрөнгө
<b>Машин тоног, төхөөрөмж</b>										
4	Печь	LG	2024	шинэ	ш	2	289,000	578,000	Эмэгтэйчүүдийн зөвлөл	
5	Ус цэвэршүүлэгч	Water care	2024	шинэ	ш	5	850,000	4,250,000	ДЗОУБ	
	Машин тоног төхөөрөмжийн дүн							4,828,000		
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>							6,588,000		